

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХОЁР ДАХЬ
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ХАМТАРСАН ХУРАЛДААНААС ГАРГАСАН
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 10 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 09 дүгээр сарын 15, 17, 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо, бусад Байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2-т заасны дагуу Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд 2025 оны 09 дүгээр сарын 29, 30-ны өдөр, 10 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж, санал, дүгнэлт гарган Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанд танилцуулсан болно.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийх үед хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, санал гаргаагүй байна.

Хууль зүйн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо, Өргөдлийн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэх үед хуралдаанд оролцсон гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй бөгөөд Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг төрийн албан хаагчдын орон тоог есөн хувиар бууруулах бодлогын хэрэгжилт болон төсвийн урсгал зардлыг бууруулснаар хууль, шүүхийн байгууллагуудын үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх талаар, Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг төсөлд тусгах боломжтой эсэх, Өргөдлийн болон Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороодын хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа, С.Эрдэнэбат нар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдлийн тэнцвэржүүлсэн орлого, зарлагын хэмжээг нэмэгдүүлж инфляцын түвшинтэй уялдуулан багш, эмч нарын цалин, ахмад настны тэтгэврийг нэмэгдүүлэх боломжтой эсэх, 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан явуулах бодлого, үйл ажиллагааны талаар болон Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлд төсвийн

урсгал зардлыг бууруулж, дотоодын нийт бүтээгдэхүүний 24 хувиас хэтрүүлэхгүй байхаар заасныг өөрчилж, нэмэгдүүлэн тогтоох боломжтой эсэх талаар асуулт асууж, хариулт авсан байна

Хуулийн төслийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа боловсролын салбарын багш, ажилтны цалин хөлс, нийгмийн баталгааг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд дэх нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ 2026 онд 31,600.0 тэрбум төгрөг гэснийг 490.0 тэрбум төгрөгөөр, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 2026 онд 32,980.0 тэрбум төгрөг гэснийг 490.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, үүнтэй уялдуулан холбогдох эдийн засгийн үндсэн үзүүлэлт болон харгалзах ДНБ-нд эзлэх хувь хэмжээнд өөрчлөлт оруулах гэсэн зарчмын зөрүүтэй санал гаргасныг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй байна.

Улсын Их Хурлын Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн хамтарсан хуралдаанаараа дээрх хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39, 64 дүгээр зүйлд заасныг баримтлан явуулж, дараах санал дүгнэлтийг гарган Та бүхэнд танилцуулж байна.

Хуулийн төслийг Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсвийн төсөл нь алдагдалгүй төсөв батлах бодлогын зорилтоосоо ухарсан, Төсвийн тухай хуульд нийцээгүй, дунд болон богино хугацааны хөгжлийн төлөвлөгөөнд үндэслээгүй, нийгмийн хүлээлт шаардлагад нийцээгүй, дагалдах тооцоо, судалгаа хангалтгүй байгаа тул Засгийн газар буцаан татаж, сайжруулах нь зүйтэй гэж, Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг хэлэлцэж байхад Засгийн газрын гишүүд Байнгын хороодын хуралдаанд бүрэн оролцох ёстой гэсэн саналуудыг хэлж, Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин Засгийн газраас боловсруулж байгаа Татварын багц хуулиудын өөрчлөлт нь Сангийн яамны тооцоолсноор улсын төсөвт 4.0 их наяд төгрөгийн нөлөө үзүүлэхээр байна гэсэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа таван жилийн төлөвлөгөөний төслийг Засгийн газар 10 дугаар сарын 30-наас өмнө Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар зохицуулсныг сануулж, төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 01-нд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хуулийн өөрчлөлт хэрэгжээд жил гаруйн хугацаа өнгөрөөд байхад эдгээр цаглаврын зөрчлийг арилгахтай холбоотойгоор авсан арга хэмжээний талаар асуулт асууж, хариулт авлаа.

Хамтарсан хуралдаанаар хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй бөгөөд Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулахад хамтарсан хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Х.ГАНХУЯГ

ТУС3761 9023051390 9087184

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Р.СЭДДОРЖ

ТУС3761 9023051390 9087184